НЗД-ын 1993 оны А282-р захирамжаар хүчингүй.

**УЛААНБААТАР**
**ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ**

# ТОГТООЛ

1985 оны 4 дугаар сарын 4-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

## ТӨВЛӨРСӨН НЯГТЛАН БОДОХ АНГИ БАЙГУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 385 дугаар тогтоолыг үндэслэн Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I.Багануурын районы төсөвт 1988 144 байгууллагуудын санхүү бүртгэлийн ажлыг төвлөрүүлж, нэгдсэн аж ахуйтай төвлөрсөн нягтлан бодох анги байгуулж 1985 оны 4 дүгээр сарын 15-наас эхлэн ажиллуулахыг районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Шааррийбуу/-д зөвшөөрсүгэй.

2.БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооны 1982 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан үлгэрчилсэн дүрмийн дагуу төвлөрсөн ня-бо ангийн дотоод журам, ажилтан нарын ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлэхийг районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга /н.Шааррийбуу/-д даалгасугай.

3.Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т ДААЛГАХ нь:

а/төвлөрсөн нягтлан бодох ангийн орон тоог бүртгэж, зардлыг баталж өгөх. Хотын ГЗ 87 144

б/нэгдсэн аж ахуйтай төвлөрсөн нягтлан бодох ангийг газар дээр нь зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллуулах.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

ЗАХИРГААНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ч.ЖАМБАЛ